



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 1/148

Мандалговь

Хүүхдийн төлөө аймгийн зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 17 дугаар зүйлийн 17.1.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хүүхдийн төлөө аймгийн зөвлөлийг дараах гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Хүүхдийн төлөө аймгийн зөвлөлийн тэргүүн – Аймгийн засаг дарга
Нарийн бичгийн дарга -Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

- Гишүүд:
1. Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
 2. Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
 3. Аймгийн ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн ажилтан
 4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
 5. Цагдаагийн газрын дарга
 6. Боловсрол, соёл урлагийн газрын дарга
 7. Эрүүл мэндийн газрын дарга
 8. Биеийн тамир, спортын газрын дарга
 9. Мэргэжлийн хяналтын газрын дарга
 10. Онцгой байдлын газрын дарга
 11. "Тэнгэрийн тэмдэг" хүүхдийн театрын захирал
 12. Хүүхдийн паркийн захирал
 13. "Дэлхийн зөн" Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн багийн ахлагч /зөвшилцсөнөөр/
 14. Сургуулийн нийгмийн ажилтны "Оюуны гэгээ" нийгэмлэгийн тэргүүн
 15. Аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн тэргүүн
 16. Аймгийн "Өсвөрийн улаан загалмай" нийгэмлэгийн тэргүүн
 17. Аймгийн "Өсвөрийн цагдаа" бүлгэмийн тэргүүн

Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр батлуулж, хэрэгжилтийг бүтэн жилээр дүгнэж, зөвлөлд мэдээлж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Ц.Ганзориг/-т үүрэг болгосугай.

Гурав. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсонтой холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны А/533 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

020000425